



## АРАВ. ДҮГНЭЛТ

**10.1 ОЛОЛТТОЙ ДЭВШИЛТТЭЙ, САЙШААЛТАЙ, БУСДАД ТҮГЭЭХ САЙН ТУРШЛАГА, ШИНЭ САНАЛ САНААЧЛАГА:**

**Газрын төлбөрийн талаар:**

- МУ-ын Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 110 дугаар тогтоолоор газар зохион байгуулалт, газрын төлөв байдал, чанарын үнэлгээний мониторингийн сүлжээ, газрын биржийн болон газрын үнэлгээ, төлбөр, татвар, хураамж, газрын кадастрын бүртгэлийн цахим систем бүхий газрын нэгдсэн сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлж, улсын хэмжээнд хэрэгжүүлж эхэлсэн нь газар өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой өргөдөл, хүсэлтийг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр шийдвэрлэж, газрын тэгш, хүртээмжтэй хуваарилах боломжийг бүрдүүлж байна.
- Ашигт малтмалын хэрэг эрхлэх газраас ашигт малтмалын үйл ажиллагаа явуулах ашиглалтын 236 тусгай зөвшөөрөл олгогдоноос 77.1 хувьд нь буюу 182 тусгай зөвшөөрлийн 117251,86 га газарт газрын төлбөрийг ногдуулсан ба үүнээс Даланжаргалан сум, Өргөн суманд үйл ажиллагаа явуулж байгаа ашиглаж байгаа тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн ашиглаж байгаа талбайд газрын төлбөрийг бүрэн ногдуулж, орон нутгийн орлогыг бүрдүүлсэн байна.
- Газрын төлбөрийн орлогын 2023-2024 оны төлөвлөгөөг биелүүлэх ажлын хүрээнд тус газраас сумдын газрын төлбөрийн батлагдсан төлөвлөгөөг хэрхэн биелүүлж ирсэн байдал, гүйцэтгэл, тайлан мэдээнд сар бүр хяналт тавьж, сар бүрийн орлогын батлагдсан төлөвлөгөөний гүйцэтгэлийн талаарх мэдээлэл, шаардлагатай авах арга хэмжээний үүрэг чиглэлийг нийт сумдад тухай бүр өгч ажиллажээ.
- Газрын төлбөр болон түүний барагдуулалтын талаарх мэдээ, мэдээллийг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, байгууллагын цахим хуудас, фэйсбуу хаяг, мобайл сурталчилгааны үйлчилгээгээр дамжуулан иргэд, олон нийтэд хүргэн ажиллаж, өр барагдуулах аянг тодорхой хугацаануудад зохион байгуулж, Аймгийн татварын хэлтсээс 7638 татвар төлөгчид масс мессэж илгээсэн, 1898 татвар төлөгчид нэхэмжлэл хүргүүлж, 257 татвар төлөгчийн банкны харилцах данс хаасан, 1 татвар төлөгчийн хөрөнгө битүүмжлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна.
- Тус байгууллагаас сумдын газар зохион байгуулалтын талаар гарсан шийдвэр, газрын нэгдсэн сангийн хөтлөлт зэрэг 12 сумын газрын даамлын үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж, Засаг даргын захирамжаар гарсан эзэмшүүлэх, ашигуулах газрын хэмжээ зөруүтэй, давхар ногдуулсан газрын төлбөр зэрэг зөрчлийг илрүүлж холбогдох арга хэмжээ авч, зөрчлийг арилгасан байна.

**Санхүүгийн үйл ажиллагааны талаар:**

- Тус газар нь 2023 онд Барилгын хөгжлийн төв ТӨҮГазартай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө болон аймагт хэрэгжүүлэх барилга байгууламжийн ажилд захиалагчийн техникийн хяналт гүйцэтгүүлэх гэрээний хэрэгжилтийг хангахад идэвх санаачлагатай ажиллаж, улсын хэмжээнд 2-р байр эзэлсэн.
- 2024 онд Монгол улсад газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойг угтан дэвшиүүлсэн “Бүсчилсэн хөгжлийг дэмжих-Хариуцлагатай газрын харилцаа”-дэвшиүүлсэн зорилтыг биелүүлж, Тэргүүн байранд шалгарсан.



3. Системийн хэмжээгээр гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтээр 2023 онд 90,1 оноо буюу Mash сайн, 2024 онд 91,72 оноо буюу Mash сайн үнэлгээ тус тус авсан зэрэг сайшаалтай ололттой талууд байна.

## 10.2. ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ ДУТАГДАЛ, ШАЛТГААН НӨХЦӨЛ:

### **Газрын төлбөрийн талаар:**

1. Газрын төлбөрийн орлогыг аймгийн хэмжээнд 2023 онд 14,1 хувиар, 2024 онд 39,1 хувиар тус тус тасалдуулсан, өмнөх онд ногдуулсан газрын төлбөр нийт барагдуулаагүй үлдэгдлийн 54,3 хувь буюу 1,7 тэрбум төгрөгийг эзэлж байгаа нь төлбөрийг барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулаагүй, томоохон аж ахуйн нэгж байгууллагын газрын төлбөрийг барагдуулж, иргэдийн эзэмшүүлсэн, ашигласан газрын төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүйтэй холбоотой байна.
2. Газрын төлбөрийн үлдэгдлийн 68.1 хувийг уурхайн газрын төлбөрийн үлдэгдэл эзэлж байгаа ба Уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид Газрын тухай хуульд заасны дагуу хариуцлага тооцож газар ашиглах эрхийг хүчингүй болгосон ч Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.16-д заасан “ashiглалтын тусгай зөвшөөрөл”- бүхий ашигт малтмал ашиглах эрх олгосон баримт бичгээр “газрын гадаргуу, түүний хэвлий, хүдрийн овоолго, хаягдал, байгалийн уснаас ашигт малтмал ялган авах, олборлох … болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг явуулах зэргээр газар ашиглах эрхийг шууд олгож үйл ажиллагаа нь үргэлжлүүлэн явагддаг, мөн тусгай зөвшөөрлийг цуцлах хууль эрхзүйн үндэслэлд төлбөр татвар төлөхтэй холбогдсон асуудлыг тусгаагүйгээс төлбөрөө төлөхгүй байх боломжийг бий болгож байна.
3. МУ-ын Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 110 дугаар тогтоолоор газрын нэгдсэн сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлж хэрэгжүүлсэн хэдий ч 2024 оны эхэнд өмнөх оны үлдэгдэл 29.241,9 мянган төгрөгөөр зөрүүтэй татагдсан, гэрээний хугацаа дууссан газрын төлбөрийн төлөгдөөгүй үлдэгдэл 95.947,8 мянган төгрөг оны эхэнд татагдаагүй орхигдсон зэрэг нь нэгдсэн цахим системийн хөгжүүлэлт, шинэчлэлтэй холбоотой.
4. Татварын Ерөнхий газраас ирүүлсэн 2024 оны жилийн эцсийн байдлаар аймгийн газрын төлбөрийн нийт үлдэгдэл 5,3 тэрбум төгрөг, ГХБХБГ-ын нэгдсэн цахим системээрх газрын нийт төлбөрийн үлдэгдэл 3,6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй ба 1,7 тэрбум төгрөгийн зөрүүтэй гарч байгаа нь 2 системийн хоорондын мэдээлэл солилцох буюу төлөв шилжихгүйтэй мөн 2019 оноос өмнөх нэхэмжлэхээр үүссэн 1,5 тэрбум төгрөгийн төлбөрөөс 1,3 тэрбум төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлж төлөлтийг бүртгээд байгаа боловч татварын системд үүссэн нэхэмжлэхээс хасагдахгүй өөрчлөлт орохгүй байгаатай холбоотой байна.
5. Мөн татварын цахим системд төлөгдсөн газрын төлбөрийн мэдээлэл бүрэн илгээгддэггүй, газрын төлбөрийн нэхэмжлэх нэг талбар тус бүрээр ялгагдаж татвар төлөгчдөд илгээгддэггүй, татварын цахим системээс үүсгэгдээгүй нэхэмжлэх татвар төлөгч нарт хүргэгдсэн, татварын систем дээр хөрөнгийн бүртгэлийн алдаа зэргээс газрын төлбөр төлөх, тооцоо нийлэх, тайлан гаргах явцад хүндрэл үүсгэж байна. Түүнчлэн татварын удирдлагын системд мал бүхий иргэдийн малын тоог оруулсан боловч хөрөнгийн бүртгэлээр хэрхэн бүртгэх асуудал шийдвэрлэгдээгүйгээс бэлчээрийн төлбөрийн ногдуулалт, нэхэмжлэхийг үүсгэх боломжгүй байна.
6. Аймгийн хэмжээнд нийт 287230.61 га талбайд 236 ашигт малтмал ашиглах зөвшөөрөл олгогдоноос 2024 оны байдлаар нийт тусгай зөвшөөрөлтэй



талбайн 77.1 хувь буюу 182 тусгай зөвшөөрлийн нийт 117251.86 га талбайн газар ашиглах эрхийг баталгаажуулж, төлбөр ногдуулан, нэхэмжлэх үүсгэсэн байна. Харин нийт тусгай зөвшөөрөлтэй талбайн 59.8 хувь буюу 169978.75 га газарт газрын төлбөрийг дараах нөхцөл шалтгааны улмаас ногдуулах боломжгүй байна. Үүнд:

- МУ-ын Ашигт малтмалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.11-т заасны дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь газар ашиглах эрхтэй ба энэхүү эрхийг орон нутгийн захиргааны байгууллагаас Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2-т, Газрын хэвллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2-ийн 2 дахь хэсэгт зааснаар олгох бөгөөд дээрх хууль тогтоомжийг хэрэгжүүлэхдээ Газрын тухай хуульд нийцүүлэхээр заасан. Харин Газрын тухай хуулийн 32 дугаар зүйл, 44.8 дахь хэсэгт зохицуулснаар газар ашиглуулах асуудал тухайн газрыг ашиглахыг хүссэн этгээд хүсэлт гаргасны дагуу шийдвэрлэгдэх, өөрөөр хэлбэл захиргааны байгууллагын санаачлагаар бус хүсэлт гаргагч этгээдийн санаачлагаар хийгдэхээр зохицуулсан.
  - Газрын тухай хуулийн 55.1-т “газрын хэвллийг ашиглахтай холбогдсон үйл ажиллагаа нь улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сум, нийслэл, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан байна” гэж заасан шаардлагын дагуу ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөлтэй талбайг сумын тухайн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах зайлшгүй шаардлагатай, улмаар сумын Засаг даргаас газар ашиглах эрхийг баталгаажуулж, гэрээ байгуулан, газрын төлбөр ногдуулж, хураах суурь нөхцөл болох юм. Гэвч сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөлтэй талбайг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгахаас татгалзсан нь аймаг орон нутгийн төсөвт 96721.6 мянган төгрөгийн газрын төлбөрийн орлого олох боломжийг хаасан байна.
7. 2023-2024 онд сумын Засаг даргын захирамжаар газар эзэмшүүлж байгаа боловч эзэмшүүлсэн, ашиглуулсан газрыг газар зохион байгуулалтын нэгдсэн санд газрыг бүртгээгүй орхигдуулсан, газрын хэмжээ зөрүүтэй, илүү, дутуу бүртгэсэн, давхардуулж газрын төлбөр ногдуулсан зэрэг нь албан хаагчдын буруутай үйл ажиллагаа, ажлын хариуцлага сүл, хяnamгай байдалтай холбоотойгоор, нэгдмэл сангийн үнэн зөв, иж бүрэн байх зарчим алдагдаж, иргэн, ААНБ-ын газар эзэмших эрх зөрчигдэж, маргаан үүсэх эрсдэлийг бий болгож, газрын төлбөрийн төлөгдөөгүй үлдэгдэл буруу гарсан эрсдлийг үүсгэсэн байна.
8. 2023-2024 онд нийт 188 нэгж талбарын газрын эзэмших эрхийг цуцалснаас өмнө онд ногдуулсан газрын төлбөрийн 1240,9 мянган төгрөгийн орлогын үүсгэсэн нэхэмжлэх устаж, төвлөрүүлэх боломжгүй болж байгаа нь газрын төлбөрийн орлогын биелэлтэнд нөлөөлж, барагдуулах арга хэмжээг цаг тухайд нь авч ажиллаагүйгээс орон нутгийн орлогын төлөвлөгөө тасалдах нэг шалтгаан болсон.
9. МУ-ын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-д дуудлага худалдаанд оролцогчдод төлбөрийн чадварын



талаарх шаардлагыг тусгаагүйгээс сонирхож буй ямар ч иргэн, хуулийн этгээд оролцон, тэдгээр нь худалдан авах өөрийн санхүүгийн боломжоос хэтэрсэн, газрын үнийг хэт хөөрөгдүүлэх явдал гарч байна. Мөн Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас газрын дуудлага худалдааны орлогын төлөвлөгөөг үндэслэлгүйгээр нэмж өндөр төлөвлөж байгаа нь дуудлага худалдааны орлого тасрах гол шалтгаан болж байна.

#### **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:**

1. Тус байгууллагад ажиллах боловсон хүчний дутмагаас төрийн жинхэнэ албан тушаалын сул орон too нөхөгдөх боломжгүйгээс төрийн ажлын чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор төрийн албаны шалгалтад ороогүй албан хаагчдыг томилсон, мөн албан тушаалын тодорхойлолтод заагдсан мэргэжил таарахгүй албан хаагчийг өөр албан тушаалыг гүйцэтгэж байгаа мэтээр эрх зүйн акт гаргаж, мэргэжил таарахгүй албан тушаалыг гүйцэтгэж байгаа нь Төрийн албаны тухай хуулийг мөрдөөгүй, хууль бус томилгоо хийж, төрд хохирол учруулж болзошгүй байна.
2. МУ-ын “Төсвийн тухай хууль”-ийн дагуу төсөв бага батлагдсанаас байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зардлыг барилгын хяналтын зардлаас санхүүжүүлсэн нь зардлыг зориулалт бусаар зарцуулахад нөлөөлсөн байна.
3. Шалгалтаар 2023 онд 983,389,9 мянган төгрөгийн, 2024 онд 1,309,404,4 мянган төгрөгийн, нийт 2,292,794,3 мянган төгрөгийн батлагдсан төсвийн гүйцэтгэлийн 1,0 хувьд нь зөрчил илэрч, өмнөх шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг дахин давтан гаргасан нь нягтлан бодох бүртгэлээр тавих дотоодын хяналтыг супруулсан, албан хаагчдын ажлын хариуцлагагүй байдал, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж чадаагүй, байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой бөгөөд цаашид нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт болон албан хаагчдын ажлын хариуцлагыг сайжруулж ажиллавал зөрчил, дутагдал гаргахгүй ажиллах бүрэн боломжтой гэж дүгнэлээ.

#### **ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ**

#### **САНГИЙН ЯАМНЫ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗАРТ:**

1. Газрын төлбөрийн орлогын нийт төлөгдөөгүй үлдэгдлийн 68,1 хувь нь уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдтэй холбоотой байна. Газрын тухай хуулийн 7.1 /Газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Газрын төлбөрийн тухай хуулийн дагуу газрын төлбөр төлнө/, 55.1 /Газрын хэвлийг ашиглахтай холбогдсон үйл ажиллагаа нь улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сум, нийслэл, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан байна/, Газрын төлбөрийн тухай хуулийн 9.1 /Газрын төлбөрийг газар эзэмших, ашиглах эрхийг улсын бүртгэлд бүртгэгдсэн буюу Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд улсын бүртгэлийн дугаарыг оруулсан өдрөөс эхлэн тооцно/ гэж тус тус заасан. Гэтэл Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.16 /“ашиглалтын тусгай зөвшөөрөл” гэж энэ хуулийн дагуу ашигт малтмал ашиглах эрх олгосон баримт бичгийг ойлгоно/ гэж тодохойлсон ба тус хуулийн 9.1.1-т “геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн хайгуулын болон энэ хуулийн 24.1-т зааснаас бусад тохиолдолд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох талбайг солбицлоор тогтоож, нийтэд мэдээлэх” гэж заасны дагуу ашигт малтмал ашиглах эрхийг



олгож, үйл ажиллагаа нь шууд явагддаг, тусгай зөвшөөрлийг цуцлах хуулийн үндэслэлд газрын төлбөр бүрэн төлж барагдуулах талаар тусгадаагүй байна.

Иймд дээрхи хуулиудын зөрчилдэж байгаа заалтуудыг нэг ойлголттой болгож, ашигт малтмалын тухай хуулинд тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэлд хуулийн этгээд нь газрын төлбөрийн төлбөрийг бүрэн барагдуулах талаар тодорхой тусгаж, үссэн төлбөрийг барагдуулахад анхаарах

2. МУ-ын Ашигт малтмалын тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Газрын хэвлэлийн тухай хуульд газар ашиглауулах асуудал тухайн газрын ашиглахыг хүссэн этгээдийн хүсэлтээр бус захиргааны байгууллагын санаачилгаар шийдвэрлэх асуудлыг тусгах талаар судлах.

#### **АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД:**

1. Дуудлага худалдааны орлогын төлөвлөгөөг аймаг, сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хотын болон чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, өмнөх онуудын суурь судалгаа, орлогын биелэлт зэргийг харгалзан, дуудлага худалдааны орлогыг төлөвлөж байх.

#### **АЙМГИЙН ТАТВАРЫН ГАЗАРТ:**

1. 2024 оны жилийн эцсийн байдлаар газрын төлбөрийн 2023 оноос өмнөх барагдуулаагүй төлбөрийн үлдэгдэл 1,7 тэрбум төгрөгийг харьяа сумдын татварын улсын байцааг нараар барагдуулж, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэхэд тодорхой хугацаатай ажил зохион байгуулах.
2. 2019 оноос өмнө нэхэмжлэхээр үссэн 1,5 тэрбум төгрөгийн 1,3 тэрбум төгрөгийг төсвийн орлогын дансанд барагдуулсан төлөлтийг татварын системд үссэн нэхэмжлэхээс сүүтган тооцож өөрчлөлт оруулах арга хэмжээг авч, 2025 оны 06 дугаар сарын 01-ний дотор хариу ирүүлэх.

#### **ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАРТ:**

1. Газрын төлбөрийн нэхэмжлэх нэгж талбар тус бүрээр ялгагдаж татвар төлөгчдөд илгээгдэж болох асуудлыг судлах.
2. Газар зохион байгуулалтын нэгдсэн системд үссэн нэхэмжлэх, төлбөр телсэн мэдээлэл, Татварын систем дээр газрын төлбөр төлөгдсөн мэдээлэл тухай бүрт нь илгээгдэхгүй байгаа алдааг судалж, шинэчлэх.
3. Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд газрын төлбөрийн төлөгдөөгүй үлдэгдлийг үнэн, зөв гарч байх талаар системийн хөгжүүлэлт, шинэчлэлтийг хийх.
4. Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д заасны дагуу дотоодын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх.

#### **АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД:**

1. Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн "Улсын төсвөөс санхүүждэг агентлаг, байгууллагын төрийн үйлчилгээний албан хаагчдад мөнгөн дэмжлэг үзүүлэх тухай" 12/06 дугаар тогтоол, 2023 оны 12-р сарын 05-ны өдрийн "Дорноговь аймгийн 2024 оны төсөв



батлах тухай" 15/08 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн "Аймгийн ИТХ-ын тогтоолыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" А/528 дугаар захирамж, 2024 оны 04-р сарын 24-ний өдрийн "Зарим агентлаг байгууллагын албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдэл олгох тухай" А/380 дугаар захирамж гарч, байгууллагын нэмэлт дансанд санхүүжилтийн харилцах дансанд орон нутгийн нэмэгдлийн санхүүжилтийг олгож, төрийн албан хаагчдийн тогтворт суурьшилтай ажиллуулах нийгмийн баталгааг хангах нөхцлийг бүрдүүлж байгаа хэдий ч орон нутгийн нэмэгдлийн ээлжийн амралттай, өвчтэй, чөлөөтэй, ажиллаагүй албан хаагчдад олгосон, орон нутгийн нэмэгдлийн санхүүжилтийг илүү олгосон, тооцоо бодоогүй, акт үйлдээгүй, эргүүлж орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлээгүй төсвийг зориулалтаар нь зарцуулж чадаагүй байна. Иймд улсын төсвөөс санхүүждэг төрийн байгууллагуудад 2023-2024 онд олгосон орон нутгийн нэмэгдэл хэрхэн олгогдсон эсэхэд дотоодын хяналтыг хэрэгжүүлж, орон нутгийн нэмэгдлийн санхүүжилтийн тооцоог тухай бүр хийж, тооцоо бодсон актаар баталгаажуулж, олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлийг орон нутгийн төсвийн орлогын дансанд буцаан төвлөрүүлэх нь зүйтэй байна.

### **ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАРТ:**

Тус байгууллагад ажиллах боловсон хүчин дутмагаас төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо нөхөгдөх боломжгүйгээс төрийн ажлын чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор төрийн албаны шалгалтад ороогүй албан хаагчдыг томилох, төрийн жинхэнэ албан тушаалд ажил гүйцэтгэх гэрээгээр ажиллуулах, албан тушаалын тодорхойлолтод заагдсан мэргэжил таarahгүй албан хаагчийг өөр албан тушаалын чиг үүргийг гүйцэтгэж байгаа мэтээр эрх зүйн акт гаргаж, мэргэжил таarahгүй албан тушаалыг гүйцэтгэж байгаа зэрэг хууль бус томилгоонд зөвлөгөө зөвлөмж өгч, хяналт тавьж, арга хэмжээ авч ажиллах.

### **СУМДЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД:**

1. Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөлтэй талбайг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, аймаг орон нутагт газрын төлбөрийн орлого олох боломжийг бий болгох.

### **ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ:**

1. МУ-ын Төрийн албаны тухай хуульд заасны дагуу захирах, захирагдах ёсыг баримтлах зарчмыг мөрдүүлж, сумдын газрын даамлын ажлын хариуцлагыг сайжруулж, чадваржуулах, газрын төлбөрийн орлогын биелэлтийг хангуйж ажиллах .
2. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д заасны дагуу дотоодын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх.
3. Монгол Улсын Сангийн яамны Санхүүгийн хяналт, Эрсдэлийн удирдлагын газрын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Сангийн сайдын баталсан 01 дүгээр, Албаны даргын баталсан 07 дугаар удирдамжийн дагуу аймгийн Газрын



харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2019-2020 оны санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагаанд хяналт шалгалтыг гүйцэтгэж, шалгалтаар 3,400,102,0 мянган төгрөгийн улсын ахлах байцаагчийн 8 акт тогтоогдож, улсын ахлах байцаагчийн 7 албан шаардлага бичигдсэнээс 3,386,592,8 мянган төгрөгийг барагдуулж, 13,509,2 мянган төгрөгийн актын төлбөрийн үлдэгдэлтэй байгаа тул актын төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч, 2025 оны 05-р сарын 01-ний өдрийн дотор албан бичгээр хариу ирүүлэх.

Энэ удаагийн шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, нэгбүрчилсэн актаар тогтоогдсон төлбөрийг актны хугацаанд барагдуулж, хугацаатай албан шаардлагаар өгсөн зөрчлийг арилгаж, шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 01-ний дотор албан бичгээр ирүүлэх

#### НЭГДСЭН АКТ БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  
Б.ЗОЛЗАЯА

Ж.БОЛОР-ЭРДЭНЭ

ШАЛГАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧ

П.МЕНХ-ЭРДЭНЭ  
Ц.БАЯРМАА

ДОТООД АУДИТОР

САНХҮҮГИЙН УДОГЗОЛМАА  
БАЙЦААГЧ  
Э.ЗОЛЗАЯА

#### ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН:

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТУРГОРДОН ГҮҮЦЭТГЭГЧ

Л.ОЛЗБАЯР  
(2025 оны . . . сарын . . . өдөр)  
БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН  
ХЭЛТСИИН ДАРГА

Ц.БАЯРМАА  
ГАЗРЫН ҮНЭЛГЭЭ, ТӨЛБӨР ТАТВАРЫН  
АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ  
МЭРГЭЖИЛТЭН

Н.ОЮУНГЭРЭЛ  
(20. . . оны . . . сарын . . . өдөр)  
НЯГТЛАН БОДОГЧ

Д.САЙНТУЯА  
(20. . . оны . . . сарын . . . өдөр)

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТИН ГАЗРЫН ДАРГА  
А.АМГАЛАНЗАЯА



3314197. ЭТО675. 0625030018